



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН  
НЭР ДЭВШИГЧ Э.ЭНХ-ОРЧЛОН ТАНАА

2020.08.31 № 257  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Энхбаатар овогтой Энх-Орчлонгийн /ЕЙ93031150/ сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Бие даан нэр дэвшигч иргэн Энхбаатар овогтой Энх-Орчлонгийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Энхбаатар овогтой Энх-Орчлонгийн/ЕЙ93031150/ мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд  
Хавсралт ..... хуудастай.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

00802041

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Э.ЭНХОРЧЛОН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2020.07.24

000000001

A handwritten signature in black ink, appearing to be "Энх" (Enkh).

A large, stylized handwritten signature in black ink, likely belonging to the official mentioned in the text above.

A smaller handwritten signature in black ink, possibly a second official or a witness.



**БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЭНХБААТАР ОВОГТОЙ  
ЭНХОРЧЛОН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Говьсүмбэр аймгийн сонгогчид оо**

**2020.07.24**

Миний үеэл ах Монгол улсын үндсэн хууль батлалцаж байсан Шаравын Насанбуян нь аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгчөөр удаа дараа сонгогдож, аймгийн нэгдсэн эмнэлийн даргаар олон жил ажиллаж байсан туршлагатай, үнэнч шударга, хариуцлагатай боловсролтой сэхээтэн хүн байсан. Энэ хүний удмын хүний хувьд үйл хэргийг үргэлжлүүлэн аймаг орон нутгаа хөгжүүлэх зорилго тавих аймгийн иргэдийн хуралд төлөөлөгчөөр бие даан 1-р багаас нэр дэвшихээр шийдвэрлэсэн юм.

Орон нутгийн бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдийг дэмжиж ажиллах тэдний эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарч байна гэж харж байна. Мөн намчирхал талцал хэрээс хэтэрсэн байдал нь нутгийн иргэдийн эв нэгдэл, хамтын хөдөлмөр, хамтыг хүчийг сулруулж аймгийн хөгжил цэцэглэлтийг удаашруулж байна.

**Бид үүнийг зүгээр хараад сууж болохгүй.**

Миний үеийн ирээдүй болсон 1990 оны залуучууд бид нэгдэн орон нутгийн хөгжил цэцэглэлтийн төлөө дуу хоолойгоо нэгтгэн над шиг залуус орон нутгийн сонгуульд нэр дэвшин гэж найдаж байна. Бид эрүүл саруул ирээдүй, шинэ өнгө төрх, шинэ санаа залуу хүний эрч хүчээр хөгжлийн түүчээ болон аймгаа хөгжүүлнэ.

**Тиймээс сонгогч Та:**

- Унаган нутгийн хүү
- Өөрийн гэсэн үзэл бодол байр суурьтай
- Үнэнч шударга, үнэт зүйлтэй
- Хөдөлмөрч, хариуцлагатай

Тийм л хүн танд үйлчилж, таны төлөө, орон нутгийнхаа төлөө бодлого гаргаж хэрэгжүүлэх болно. Ийм хүмүүс бүрдсэн төрийг Та миний төр гэж төрдөө итгэлтэй байх болно.

**Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах зүйлийг зорилт болгон дэвшүүлж байна.**

- Төмөр замын дан байр, багш нарын байр, геологичдийн байрыг төвийн цэвэр, усны шугаманд холбох

2 жилийн хугацаанд үе шаттай хийж гүйцэтгэнэ

0000000002

14454  
10018040

- Төмөр замын дан байрнуудын голд эко 00-ыг олноор байршуулах  
Олон улын төсөл хөтөлбөрөөр

- Төмөр замын клубын өмнөх талбайг томсгож, тохижуулах

- Ашиглалтын хугацаа дууссан орон сууц, барилгуудыг нурааж шинэ орон сууцны хотхон байгуулах

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх, зохион байгуулалтын ажлыг хийх

- Авто замын сүлжээг нэмэгдүүлэх

Хорихын 5 давхар хүртэл, Балдан засаг захын урдуур авто болон явган замуудыг тавих нийт 2 км орчим

- Хогийн цэгүүдийн савыг шинэчилж, ангилан ялгадаг хогийн саваар хангах  
Олон улсын төсөл хөтөлбөрөөр

- Төмөр замын байрнуудыг сууц өмчлөгчдийн холбоо байгуулна.  
Зохион байгуулалт хийнэ

- Урт дэнжийн баруун талд тохижилтын ажлыг сайжруулах  
Бүх насны иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулах

- Мах комбинат байгуулах  
Хувийн хөрөнгө оруулалтаар үйлдвэр байгуулж, орон нутгийн иргэдийг эрүүл хүнсээр хангах

- Багийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа цэвэр усны шугам хоолойг шинэчлэх  
Төмөр замын байгууллагын хөрөнгө оруулалтаар төмөр шугам хоолойг хуванцар шугамаар сольж, багийн иргэдийг эрүүл цэвэр усаар хангана

Шинэ үе, шинэ сонголт, эрч хүч энэ орон нутгийг хөгжлийн түүчээ байх болно

БОЛОВСРУУЛСАН:



Э.ЭНХОРЧЛОН



0000000003  
